



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 563

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 47,950,000.00 (дөчин долоон сая есөн зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга С.Түвшинтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020 оны 11  
дүгээр сарын 03-ны  
өдрийн 603 дүгээр тогтоолын  
хавсралт

**"Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

| № | Автомашины марк, улсын<br>дугаар, зориулалт,<br>хөдөлгүүр, арлын дугаар                     | Ашиглал<br>тад орсон<br>он | Нийт<br>гүйлт /км/ | Балансын үнэ,<br>Хуримтлагдсан<br>элэгдэл /төгрөг/                      | Сэлбэгээр<br>орлогод авах үнэ<br>доод үнэ<br>/төгрөг/ |
|---|---------------------------------------------------------------------------------------------|----------------------------|--------------------|-------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------|
| 1 | катер 638 маркийн ХӨ М01<br>улсын дугаартай, моторт<br>завь, хөдөлгүүр дугаар 1F-<br>880428 | 2007                       | 1034               | 47,950,000.00                                                           | 1,000,000.00                                          |
|   |                                                                                             |                            |                    | 47,950,000.00                                                           | 1,000,000.00                                          |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                                   |                            |                    | <b>47,950,000.00</b><br>(дөчин долоон<br>сая есөн зуун<br>тавин мянган) | <b>1,000,000.00 (нэг<br/>сая)</b>                     |